



УУЛ УУРХАЙ
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт

Л.Отгонтуяа, MERIT төслийн Үндэсний зөвлөх
2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр

Агуулга

Төсөв боловсруулах үйл явц

Төсвийн мөчлөг

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт

Төсөвт жендэрийн дүн шинжилгээ хийх

Төсөв боловсруулах үйл явц

- Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагын эрхлэх асуудлуудын нэг юм.
- Томоохон байгууллагууд (ОУВС, ЭЗХАХБ гм)-ын норм, стандартыг баримталдаг.
- Өнгөрсөн хэдэн арван жилд ихээхэн өөрчлөгдсөн.
- Олон улсын норм, практикт тулгуурласан хэдий ч тухайн улсын онцлогийг тусгадаг.

Төсөв

Төсөв нь төрийн чиг үүргийн хүрээнд тодорхой хугацаанд зорилго, зорилт бүхий цогц арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө юм. Төлөвлөгөө нь шаардлагатай нөөцийн тооцооллыг өмнөх нэг буюу түүнээс дээш тайлант хугацааны гүйцэтгэлтэй харьцуулсан боломжит нөөцийн тооцоолол, ирээдүйд шаардагдах хөрөнгийг хамтаар харуулдаг.

Төсвийн үүрэг, төсөвлөлтийн арга

Хяналтын арга хэрэгсэл (Controlling)

- Зардлыг объектоор нь хянах
- Зүйл-заалтын төсөв
- МУ: 1921 оноос хойш 100 жил

Удирдлагын арга хэрэгсэл (Management)

- Төрийн үйлчилгээний үр ашиг, үр дүнг чухалчлах
- Гүйцэтгэлд суурилсан төсөв
- МУ: 2003 оноос хойш 18 жил

Төлөвлөлтийн арга хэрэгсэл (Planning)

- Урт хугацааны хөтөлбөрийн зорилт ба байгууллагын төлөвлөлтийг уялдуулах
- Хөтөлбөрт төсөв
- МУ: 2008 оноос хойш 13 жил

--- Төсөв

- Улс төрийн хариуцлага тооцох арга хэрэгсэл
- Санхүүгийн эгэх хариуцлагын арга хэрэгсэл
- Удирдлагын эгэх хариуцлагын арга хэрэгсэл
- Харилцааны хэрэгсэл
- Бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, тогтоох, зохицуулах боломж
- Эдийн засагт нөлөөлөх, зохицуулах арга хэрэгсэл

Төсвийн мөчлөгийн үе шат

- Боловсруулж, бэлтгэх;
- Батлах
- Хэрэгжүүлэх
- Хянаж үнэлэх, тайлагнах.

Төрөөс баримтлах бодлого

Төр төсвийн орлого болон зарлагыг тэнцвэржүүлэхийг илэрхий чармайдаг. Улсын төсөвт санхүү, нийгэм, эдийн засгийн бодлогыг тоймлон тусгахын зэрэгцээ энд хийгддэг гол тооцоолол нь ирэх жилийн төсвийн зарлагыг дэлгэрэнгүй төлөвлөж оруулдаг.

Зарчим

Нэгдмэл байх – нэгдсэн төсөвт орлого орж, түүнээс зарлага гардаг байх

Тэнцвэржүүлэх – төсвийн нийт орлого нийт зарлагаа нөхөж байх

Жилдээ багтах

Онцгой тохиолдол

Уругвай Улс Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд батлагдсан нэг төсөвтэй байдаг. Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацааны эхэнд парламентын танхимд төсвөө өргөн барьж, батлуулдаг бөгөөд дараагийн сонгууль хүртэл тухайн төсвийг баримталдаг.

Эгэх хариуцлага



Хариуцлага нь төсвийг төлөвлөж эхлэхээс эхлээд хэрэгжилтийн төгсгөлд төрийн хяналт шалгалт буюу гүйцэтгэлийн аудит хийж, үр дүнг тайлагнах хүртэл бүх үйл явцыг бүрэн хамарна.



Босоо шатлалтай тогтолцоонд тухайн байгууллага чиг үүргээ гүйцэтгэж байгаа эсэхэд дээд шатны парламентын гишүүд, төрийн хяналтын байгууллага хяналт тавьдаг.



Хэвтээ тогтолцоонд олон нийт, иргэний нийгмийн байгууллагууд, бусад ашиг сонирхол хөндөгдөгч талууд хяналт, үнэлгээнд нь оролцож, үйл ажиллагааг нь хянадаг.

Монголын төсөвлөлтийн төлөв байдал

Монгол Улс “**хөтөлбөрт төсөвлөлт**”-ийн аргыг 2008 оноос туршин хэрэгжүүлж эхэлсэн, 2013 оноос үндэсний хэмжээнд энэхүү аргыг ашиглан төсвийг төлөвлөдөг болсон юм.

Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль батлагдаж, 2016 оноос хэрэгжиж эхэлснээр урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах болон төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэхдээ үр дүнд суурилсан аргыг ашиглаж байна.

Шалгуур үзүүлэлт Монгол Улсад

Монгол Улсын үр дүнд суурилсан төлөвлөлтийн тогтолцоо нь **хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан чанарын болон тоон үзүүлэлт** хэмээн тодорхойлсон шалгуур үзүүлэлтэд тулгуурладаг байдаг. Гарцын шалгуур үзүүлэлтийг ихэвчлэн байгууллага, бодлого, хөтөлбөр, төслийн үйл ажиллагаанаас шууд бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын болон тоон үзүүлэлт гэж тодорхойлдог.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт (ЖМТ) гэдэг нь жендэрийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсвийн бодлого, удирдамжтай байхыг хэлнэ. Аль ч шатны төрийн байгууллага, түүний төсвийн ерөнхийлөн захирагч нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг үнэлж, түүнийг харгалзан гол үр дүн, зорилгыг тодорхойлж, төрийн сангийн хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, энэ тал дээр гаргаж буй ахиц амжилтаа хянаж үнэлэх чадвартай байвал зохино.

Дэлхийн олон орон жендэрийн тэгш байдлыг хангахын тулд **жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт** хийхэд анхаарлаа хандуулж, олон өөр арга замыг ашиглах болсон.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт

- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт гэдэгт төсвийн хөтөлбөр, бодлогууд эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлөхийг системтэйгээр үнэлэн шалгахыг ойлгоно.
- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт гэдэг нь зөвхөн тусгайлан эмэгтэйчүүдэд чиглэсэн хөтөлбөрүүдийг шинжлэх, “эмэгтэйчүүдэд зориулсан” тусдаа төсөв төлөвлөх бус, харин төрийн бүх хөтөлбөр, үйлчилгээ, бодлого дахь жендэрийн нөлөөллийг үнэлж үзэх явдал юм.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт

- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт гэдэгт төсвийн хөтөлбөр, бодлогууд эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлөхийг системтэйгээр үнэлэн шалгахыг ойлгоно.
- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт гэдэг нь зөвхөн тусгайлан эмэгтэйчүүдэд чиглэсэн хөтөлбөрүүдийг шинжлэх, “эмэгтэйчүүдэд зориулсан” тусдаа төсөв төлөвлөх бус, харин төрийн бүх хөтөлбөр, үйлчилгээ, бодлого дахь жендэрийн нөлөөллийг үнэлж үзэх явдал юм.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт


- Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах стратегийн амин чухал, салшгүй хэсэг.
- Төсвийн бүхий л үйл явцад жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах гэж ойлгож болно.
- Үндэсний, салбарын, орон нутгийн болон байгууллагын төсөвт жендэрийн үнэлгээ хийх, төсвийн үйл явцад жендэрийн үзэл баримтлалыг тусгах, улмаар төсвийг жендэрийн тэгш байдлыг хангах зорилгод нийцүүлэн сайжруулах цогц үйл явц юм.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт

- Жендэрийн тэгш байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулах Засгийн газрын төлөвлөлт, төсвийн үйл явц.
- Салбарын болон орон нутгийн бодлого, төлөвлөлт, төсөвт байгаа жендэрийн гажуудлыг илрүүлэх, түүнийг залруулах арга хэмжээг тусгах нь жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үйл явцын нэгэн хэсэг.
- **ЖМТ** - Эмэгтэй, эрэгтэй хүмүүс, охид хөвгүүдэд үзүүлэх төсвийн ялгаатай нөлөөлөлд дүн шинжилгээ хийж, төсвийн баримт бичиг, үйл явцад жендэрийн үзэл баримтлалыг системтэйгээр нэвтрүүлэхийг хэлнэ.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт

Засгийн газар жендэрийн тэгш байдлыг хангах бодлогын зорилтдоо хүрэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.



Аливаа асуудлыг жендэрийн өнцгөөс харж шинжлэх нь жендэрийн харалган байдлыг даван туулахад чухал байдаг.

Юуг жендэрийн мэдрэмжтэй төсөв гэж үзэхгүй вэ?

- Жендэрийн мэдрэмжтэй төсөв нь эмэгтэйчүүдэд чиглэсэн (гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх гэх мэт) хөтөлбөрийг төсөвт тусгах тухай асуудал биш, дан эмэгтэйчүүдэд зориулсан тусдаа төсөв тавих тухай асуудал бүр биш.
- ЖМТ нь заавал төсөвтэй холбоотой байх албагүй. Ихэнх тохиолдолд ЖМТ-ийн хүрээнд эмэгтэй, эрэгтэй хүмүүс төрийн бодлого, хөтөлбөр, арга хэмжээнээс тэгш үр шим хүртэх боломж бүрдүүлэх зорилгоор багахан өөрчлөлтийг хийхийг шаарддаг (тухайлбал, бодлого, журам, удирдамж баримт бичиг, маягтад багахан өөрчлөлт оруулах, агентлаг хоорондын ажлын уялдааг хангах гэх мэт).

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт

- Аливаа бодлого болон нөөц хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт нь эмэгтэй эрэгтэй хүмүүст, охид хөвгүүдэд хэрхэн **ялгаатай байдлаар нөлөөлж байгааг шинжлэх** боломж олгодог.
- Төсвийн үйл явцыг илүү нээлттэй болгон эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, нийгмийн бүлгүүдийн оролцоог сайжруулах, төсвийн мэдээллийг илүү хүртээмжтэй, ойлгомжтой болгох, төсвийн талаарх эрх зүйн орчныг сайжруулах олон сайн нөлөөтэй.
- Эдийн засгийг илүү өргөн хүрээтэй харах, дэлхий нийтэд ихэвчлэн эмэгтэйчүүд гүйцэтгэдэг цалин хөлсгүй хөдөлмөрийг харгалзан үзэх боломж олгодог.
- Санхүүгийн нөөцийг илүү оновчтой, үр өгөөжтэй хуваарилах, зарцуулах, нийгэм, орон нутаг, хамт олны дотор байгаа **жендэрийн аливаа асуудлыг шийдэх боломжийг бодитой болгодог.**

Эрх тэгш байдал, тэгш эрхийг тогтоож байгаа эсэх

- Төсөв эрэгтэй, эмэгтэй хүмүүст ялгаатайгаар нөлөөлж болзошгүй учраас Засгийн газрын төсөв нь “жендэрийн хувьд төвийг сахисан/саармаг” байж болохгүй.
- “Жендэрийн хувьд төвийг сахисан/саармаг” гэдэг нь үнэндээ жендэрийн хувьд харалган, мэдрэмжгүй байна гэсэн үг.
- Энэ байдлаар эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг харгалзаагүйгээс зарим хөтөлбөр тэгш бус байдлыг нэмэгдүүлэх талтай.
- Төрийн аливаа хөтөлбөр, үйл ажиллагаа, арга хэмжээ нь ард иргэдийн дунд эрх тэгш бус байдлыг санамсаргүйгээр нэмэгдүүлж байж болзошгүй.

Австралийн туршлага

Засгийн газрын яамд, агентлагуудад тухайн жилийн төсөв, ялангуяа улсын төсвийн зарлага охид, эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлөх талаар шинжилгээ хийх шаардлага тавьдаг.

Өмнөд Африкийн туршлага

- Ядуу, эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн нийгэм-эдийн засгийн хэрэгцээ шаардлагыг тэргүүн ээлжинд авч үзэх зарчим, үнэт зүйлсийн цогц нь төсвийн зарлагыг хянах арга хэрэгсэл болдог.
- Энэ зорилгоор эрэмбэлэх, төлөвлөх, хянах эрх бүхий төрийн байгууллагуудыг чадавхжуулдаг.
- Энэхүү чухал сэдвийн талаарх хэлэлцүүлэгт идэвхтэй оролцох иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулдаг.

Анхаарч үзэх жендэрийн асуудлууд

- Практикт төсөвлөлтийн үйл ажиллагаанд эдийн засгийн хувьд ач холбогдолтой байдлаар жендэрийн асуудлыг тусгах нь дүн шинжилгээний амаргүй ажил юм.
- Энд зайлшгүй асуух ёстой асуулт бол төсөв боловсруулахдаа жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт шаардлагатай гэдгийг илтгэж буй юуг орхигдуулсан байж болзошгүй вэ?
- Жендэрийн дүн шинжилгээг дутмаг оруулах явдал багтана.
- **Зөвлөмж:** Яамд, ЗДТГ-ын зарцуулалт болон Сангийн яамны зарлага, орлогын асуудал хэлэлцэгдэх бүрт нь жендэрийн дүн шинжилгээг бага багаар шигтгэж, оруулж өгөх нь зүйтэй.

PEFA (Төсвийн зарлага, санхүүгийн эгэх хариуцлагын хөтөлбөр) ба ЖМТ

Төсвийн зарлага, санхүүгийн эгэх хариуцлагын хөтөлбөрөөс 2020 онд улс орнуудын төсөв, санхүүгийн удирдлагын жендэрийн мэдрэмжтэй байдлыг үнэлэх нэмэлт механизмыг шинээр боловсруулан гаргажээ.

Уг нэмэлт механизмын дагуу улс орнуудын **төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоо** нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон эл 2 бүлэг доторх дэд бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ шаардлагыг ямар хэмжээнд харгалзан үзэж, хангаж байгааг үнэлэх зорилгоор зохих мэдээлэл цуглуулж шинжлэхийг дэмждэг юм.

**Төсвийн
зарлага,
санхүүгийн эгэх
хариуцлагын
хөтөлбөр,
төсвийн мөчлөг**



Төсвийн зарлага, санхүүгийн хариуцлагын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд (1)

- Төсвийн бодлогын төсөлд хийх жендэрийн нөлөөллийн дүн шинжилгээ;
- Төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн жендэрийн мэдрэмжтэй менежмент;
- Жендэрийн мэдрэмжтэй төсвийн удирдамж;
- Жендэрийн мэдрэмжтэй төсвийн санал, баримт бичиг боловсруулалт;
- Төрийн үйлчилгээний гүйцэтгэлийн хүйсээр ангилсан тоо мэдээлэл;

Төсвийн зарлага, санхүүгийн хариуцлагын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд (2)

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн төсвийн зарцуулалтыг тусгайлан бүртгэж, тайлагнах;
- Жендэрийн мэдрэмжтэй тайлагналт;
- Төрийн үйлчилгээний жендэрийн нөлөөллийн үнэлгээ;
- Төсвийн жендэрийн нөлөөллийн эрхзүйн (нийцлийн) хяналт шалгалт.

Төсвийн мөчлөгийн үе шатууд, тэдгээрт жендэрийг тусгах

Жендэрийн тэгш байдлыг дэмжихийн тулд төсөв санхүүгийн бодлого, удирдамжийг төсвийн үе шат бүрт ашиглан, жендэрийг тусгаж болно. Тодруулбал:

- Боловсруулж, бэлтгэх
- Батлах
- Хэрэгжүүлэх
- Хянаж үнэлэх, тайлагнах.

Төрийн албан хаагчид төсөвт жендэрийг анхаарч тусгах боломж

Дээрх дөрвөн үе шатны гуравт нь төрийн албан хаагч шууд гар бие оролцож, нөлөөлөх боломжтой. Үүнд:

- Бэлтгэх, боловсруулах
- Хэрэгжүүлэх
- Үнэлэх

Төрийн үйлчилгээг ард иргэдэд тэгш хүртээх байдлыг сайжруулах үүднээс үе шат болгонд хүйсийн тусгайлсан шинжилгээг хийж болох юм.

Төрийн санхүүд жендэрийг тусгах

2015 онд Монгол Улсын Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах байгууллага, агентлагийн жендэрийн стратегийн **Тэргүүлэх зорилт 3**-ыг дараах байдлаар тодорхойлсон байна:

Сангийн сайдын болон зарим төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн үйл явцыг үе шаттайгаар жендэрийн мэдрэмжтэй болгоно.

Бүлгийн ажил №1

- Бодлого төлөвлөлт, төсөвлөлтөд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах чиглэлээр **Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт** ямар ажлуудыг хэрэгжүүлж байгаа талаар бүлгээр ярилцаж, товч танилцуулга хийнэ үү.
- Бүлгээр ажиллах – 10 минут
- Бүлгийн ажлын үр дүнг нийтэд танилцуулах – бүлэг тус бүр 2-3 минут

Үндэсний хэмжээний хууль тогтоомж, бодлого, стратеги

- Монгол улсын Үндсэн хууль (1992);
- Иргэний хууль (2002);
- Хөдөлмөрийн тухай Монгол улсын хууль (1999);
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2005);
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011);
- Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга (2019);
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021 оны үйл ажиллагааны хөтөлбөр);
- “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн баримт бичиг;
- Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл (2021-2025 он);
- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Засгийн газрын 2020 оны 206, 216, 217, 218 дугаар тогтоол;

Бодлого төлөвлөлтөд жендэрийн тэгш байдлыг тусгах

- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн тухай хууль, ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль, тэгш цалин хөлс олгох тухай хууль зэрэг ач холбогдол бүхий хууль тогтоомжийн зохицуулалтад анхаарч ажиллах;
- Ялгаварлан гадуурхах явдлыг зогсоох зорилгоор хяналтын хороо, ажиглалтын механизмыг бий болгох;
- Макро түвшний болон салбарын бодлогод дүн шинжилгээ хийх;
- Хөтөлбөрийн үр дүн эмэгтэй, эрэгтэй хүмүүст хэрхэн нөлөөлж буйг ашиг шим хүртэгчид, албан хаагчийн хүйсээр ангилан дүн шинжилгээ хийх.

Макро түвшний зөрүү

Дэлхий дахинд эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг шинжлэн дүгнэхэд дараах хүчин зүйлс түлхүү ажиглагдаж байна:

- Жендэрээс хамаарсан цалингийн зөрүү;
- Боловсролын түвшний зөрүү (Монгол Улсын хувьд асуудал биш юм);
- Тэтгэврийн зөрүү;
- Улс төр дэх төлөөлөл, оролцооны зөрүү;
- Шийдвэр гаргах түвшний албан тушаалын зөрүү;
- Өмч, хөрөнгө эзэмших байдлын зөрүү.

Төсвийн зарлагын сонголт

Дэлхий дахинд дараах хүчин зүйлс түлхүү ажиглагдаж байна:

- Хүүхэд асрах тогтолцооны ач холбогдол;
- Асран халамжлагчдад чиглэсэн дэмжлэг туслалцааны ач холбогдол;
- Шимтгэл төлөөгүй ч хувь тэнцүүлэн тэтгэвэр олгох тогтолцооны ач холбогдол;
- Нийтийн тээвэр амьдралын чанарт нөлөөлөх ач холбогдол;
- Тэгш байдлыг хангахад чиглэсэн нийтийн номын сан, олон нийтэд тэгш мэдлэг түгээх тогтолцооны ач холбогдол.

Пакистан улсын жишээ

- Шинэ зүйл биш юм.
- Пакистан улсын 2005 оны туршлага



Төрийн бодлогын үнэлгээ, Пакистан улс

- Тус улсын эрдэмтэн судлаачид боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн бодлогын жендэрийн мэдрэмжтэй байдлын үнэлгээг хийсэн.
- Хэрэгцээ шаардлагыг ойлгох, жендэрийн тэгш бус байдлын зөрүүг тодорхойлох зорилгоор нөхцөл байдлын шинжилгээ, салбарын төсөв, бодлогын үр дүн, нөлөөлөлд дүн шинжилгээ хийлгэсэн.
- Судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулж, төсвийн үйл явцын хүрээнд салбар бүрийн тайланд заавал тусгах суурь мэдээлэл болгосон.

Үр шим хүртэгчдийн судалгаа, Пакистан улс

- Төсвийн хөрөнгө оруулалт болон төрийн үйлчилгээний иргэдэд үзүүлэх нөлөөллийн талаар эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн санаа бодлыг сонсох зорилгоор үр шим хүртэгчдийн судалгааг цөөн тооны мужид хийсэн;
- Судалгаа нь үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг хүйсээр тодорхойлох зорилготой байсан;
- Судалгааны үр дүнг холбогдох албан хаагчдад танилцуулж, дараа жилийн бодлого төлөвлөлт, төсөвлөлтөд ашиглахыг уриалсан.

Цаг ашиглалтын судалгаа, Пакистан улс

- Пакистан улсын Статистикийн албанаас нийт 20,000 өрхийг хамруулсан судалгаа хийсэн.
- Цалин, хөлсгүй хөдөлмөр, асрах ажил хийдэг хүн амыг хүйсээр ангилан харуулсан.
- Судалгааны тоон мэдээллийг төрийн бодлого, хөтөлбөр, төсөв боловсруулахад ашиглаж байна.

Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн мэдэгдэл, Пакистан улс

Төрийн байгууллагын зүгээс УИХ-ын гишүүд, иргэний нийгмийн байгууллагад жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн санал санаачилгыг хэрэгжүүлэх төсвийн хуваарилалтын талаар мэдээлэл хүргэх арга хэрэгсэл юм.

Төсөвт жендэрийн дүн шинжилгээ хийх таван алхам

- Тухайн салбар дахь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх;
- Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн тухайн нөхцөл байдалд бодлогын шинжилгээ хийх;
- Жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэхэд төсвийн хуваарилалт хангалттай эсэхэд үнэлгээ хийх;
- Төсвийн бодит зарлагад үнэлгээ хийх зорилгоор төсвийн зарлагын богино хугацааны үр дүнг үнэлэх;
- Зарлагын урт хугацааны үр дүн буюу нөлөөг үнэлэх;

Татвар, төсвийн орлого

- Засгийн газрын орлого бүрдүүлэх арга зам нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст ялгаатай нөлөөлдөг.
- Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг татварын бодлогын шинжилгээнд тусгах нь төрийн бодлогын үр дүн, чанарыг мэдэгдэхүйц нэмэгдүүлдэг.

Макро түвшний бодлого: нийгэмшил

- Төр олон нийтэд боловсрол олгох, соён гэгээрүүлэх арга хэмжээний хүрээнд хүүхдийн нийгэмшлийн талаар ямар мэдээллийг хүн ам, айл өрх, эцэг эхчүүдэд өгч байна вэ?
- Уг мэдээлэл нь тэгш бус байдлыг бататгаж, нэмэгдүүлж байгаа эсэх?

Макро түвшний бодлого: соёл

- Түүх, соёл, үлгэр домогт эмэгтэйчүүдийг хэрхэн дүрсэлдэг вэ? Бид тэдний хувь нэмрийг эн тэнцүү авч үздэг үү? Тэдний оруулж буй хувь нэмрийг зөвөөр үнэлж хүлээн авдаг уу?
- Бид ямар төрлийн соёлыг бий болгож байна вэ?

Хэлэлцүүлэг

УУХҮЯ болон агентлагуудын түвшинд Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд Та бүхэн ямар бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлэх саналтай байна вэ?

Дүгнэлт: Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт

- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг төсөв боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлгээ хийх аль ч шатанд хийж болно.
- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт нь төсвийн зарцуулалт, татварын хяналт шалгалттай л адил ойлголт бөгөөд төрийн бодлого, төлөвлөлт нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст хэрхэн ялгаатай байдлаар нөлөөлж буйг үнэлэх арга юм.
- Энгийнээр хэлбэл, уг арга нь аливаа бодлого, төлөвлөлт үр шим хүртэгчид болон цалин хөлсөнд хэрхэн нөлөөлөхийг хүйсээр ангилан үнэлгээ хийх арга гэж болно.

Дэлгэрэнгүйгээр тайлбарлавал, төрийн бодлого, төлөвлөлт нь нийгэмшил, соёл, төрийн үйлчилгээнд хэрхэн нөлөөлж, эс нөлөөлж буйг цогцоор үнэлэх үйл явц юм.

Жендэрийн стандарт агуулга

- Хүйсээр ангилсан тоо мэдээлэл;
- Салбарын жендэрийн дүн шинжилгээ;
- Байгууллагын зүгээс бодлого, төлөвлөлтөд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах чадавх;
- Нийгэмшлийн нөлөөлөл;
- Нийгэм дэх охид, эмэгтэйчүүдийн байдал;
- Дараагийн алхам: Нарийвчилсан зөвлөмж



In partnership with
Canada



**Баярлалаа.
Амжилт хүсье!**

